

МОНГОЛ, ЯПОН УЛСЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТСОН НЬ (1972 он)

Д. Бумдарь

Дэд профессор, МУИС-ШУС- Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхим

Abstract

This article traces historical terms of Mongolia-Japan's diplomatic relationship and emphasizes mutual understanding and cooperation especially sphere of economic, social, cultural relations of the two countries. This article surveys official treaty and agreements, projects and programs, furthermore to define the result of official visits by the leaders of those two countries. Therefore, emphasizes further diplomatic and strategic relations between Mongolia and Japan.

түлхүүр үг: Монгол улс, Япон улс, гадаад бодлого, дипломат харилцаа, яриа хэлэлцээр, Тайванийн байр суурь

Оршил

Монгол улс, Япон улс нь ази тивийн өнө эртний түүх уламжлалтай төр улсууд юм. Хоёр улсын хоорондын албан бус харилцаа нь урт удаан хугацааны түүхтэй. Богд хаант Монгол улсын үед Их Хүрээнд Япон улсын иргэд ирж худалдаа арилжаа хийж байсан тухай баримт мэдээг сурвалж бичгүүдэд тэмдэглэж үлдээсэн байдаг. Хоёр улсын хооронд 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайн өрнөсөн. 1972 онд хоёр улс дипломат харилцаа тогтоосон түүхтэй билээ. Монгол улс Япон улстай 1972 оны 2 сарын 24 нд дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр улсын харилцаа сааралтгүй урагшлан эрчимтэй хөгжиж ирсэн.

1939 оны дайнаас хойш 1972 онд Монгол улс, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоох хүртэлх 30 гаран жилийн хугацаан дахь хоёр улсын хоорондын харилцааг дотоодын болон гадаадын монголч эрдэмтэд нь түүхийн ухааны талаасаа судласан байдаг. Харин дээрх хугацаанд хоёр улсын хооронд өрнөсөн харилцаа нь улс төрийн шинжлэх ухаан болон олон улсын харилцааны байр суурьнаас харахан судлагдаагүй явж ирсэн байдаг. Ийм учир “Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтсон нь (1972 он)” сэдэвт судалгааны ажлын хүрээнд хоёр улсын хоорондын 1939-1972 он хүртэлх харилцааг судласан.

Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох албан бус уулзалт, яриа хэлэлцээр олон жилийн турш үргэлжилсэн бөгөөд уг үйл явцыг цаг хугацаа, үйл явдлын өрнөлийн хувьд 4 үе шатанд зааглан авч үзэж болох юм.

Нэгд, Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоох эхлэл тавигдсан үе (1957-1961); *Хоёрт*, Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар яриа хэлэлцээр өрнөж эхлэсэн үе (1961-1965); *Гуравт*, Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох үйл явцад бэрхшээл тулгарсан үе (1965-1970); *Дөрөвт*, Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон үе (1970-1972).

Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоох эхлэл тавигдсан нь

Монгол-Япон улсын дипломат харилцааны эхлэл тавьсан уулзалтуудын тэмдэглэл, баримт бичиг, хоёр улсын тэр үеийн гадаад бодлого, байр суурийг судлаж, дипломат харилцааг тогтооход нөлөөлсөн хүчин зүйлүүдийг шинжлэн үзэхэд:

1957 оны 4 дүгээр сарын 8-нд Монгол улсын цаг уурын шинжилгээний Хороонд Япон улсаас дараах утгатай албан бичиг ирүүлсэн байдаг. Уг бичигт: “харилцан ойлголцлын үндсэн дээр цаг уурын холбогдох мэдээ, материалыг солилцох хүсэлтэй байгаагаа”¹⁵⁹ илэрхийлсэн байна. Энэ нь хоёр улсын төрийн байгууллагуудын хооронд үүссэн албан ёсны харилцааны эхлэл болсон хэмээн үзэх боломжтой.

Монгол улсаас Япон улстай дипломат харилцаа тогтоох хүсэлтэй байгаагаа анх 1957 оны 5 дугаар сарын 15-нд Москва хотноо Монгол-Зөвлөлтийн дээд хэмжээний уулзалтын үеэр албан ёсоор мэдэгдсэн. Уг мэдэгдэлд: “ЗХУ болон Япон улсын хооронд гадаад харилцаагаа дахин сэргээх ойлголцол өрнөж байгааг БНМАУ-ын засгийн газар тааламжтай хүлээн авч байгаагийн зэрэгцээ, БНМАУ нь Япон улстай харилцаагаа сэргээх хэлэлцээр хийхэд бэлэн байна”¹⁶⁰ гэжээ. Энэ нь Япон улстай албан ёсны гадаад харилцаа тогтоох Монгол улсын засгийн газрын байр суурь байсан.

Уг мэдэгдлийн дараа мөн оны 8 дугаар сард Ротерийн сурвалжлагч Бээжин дэх Япон улсын элчин сайдын яамнаас Япон улсын засгийн газрын байр суурийг асууж тодруулсан байдаг. Сурвалжлагчийн асуултад Элчин сайдын яамнаас: “Япон улс нь Монгол улсын тусгаар тогтнолд бүрэн итгэлтэй бус байна; Олон улсын системд бүрэн хариуцлага хүлээх чадварт нь эргэлзэж байна; Дипломат харилцаа тогтоох бодолгүй байна”¹⁶¹ гэж дипломат харилцаа тогтоох асуудлаарх байр сууриа илэрхийлсэн байдаг.

Мөн оны 9 дүгээр сард Үнэн сонины сурвалжлагч Москва дахь Япон улсын элчин сайдаас “Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоох; Хоёр улсын эдийн засаг, соёлын харилцааг өргөжүүлэх; НҮБ-д Монгол улс гишүүнээр элсэн орох”¹⁶² асуудлаар Япон улсын засгийн газрын байр суурийг асууж тодруулахад Элчин сайд: “Эхний хоёр асуудлын хувьд Япон улс бүх улс орнуудтай найрсаг сайхан харилцах гадаад бодлого баримталдаг; НҮБ-д гишүүнээр элсэх тухайд бол энэ нь тус байгууллагын шийдэх асуудал”¹⁶³ хэмээн хариулжээ.

Дээрх эх сурвалжуудад тэмдэглэгдсэн баримтаас үзэхэд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох асуудалд ямархуу явагдаж байсныг харж болох юм.

1959 онд Москва дахь Монгол улсын элчин сайд Ц. Жамбалдорж Япон улсын элчин сайдад хандан албан бус харилцаа тогтоох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Үүнийг Монгол улсын зүгээс Япон улстай дипломат харилцаа тогтоох талаарх “анхны алхам” хэмээн Япон улсын засгийн газрын архивын баримт бичигт тэмдэглэн үлдээсэн байна.

1960 оноос Монгол, Япон улс дипломат харилцаа тогтоох асуудлаар Варшав дахь хоёр улсын элчин сайдын яамдын хооронд албан бус яриа хэлэлцээр эхлэсэн түүхтэй. Дипломат харилцаа тогтоох үйл явц эхлэл төдий байсан 1959 оны 7 дугаар сарын 29-нд Монгол-Японы худалдааны гэрээ байгуулагдсан нь хоёр улс харилцан ойлголцолд хүрч дипломат харилцаа тогтооход ойрхон байгааг илэрхийлсэн үйл явдал байжээ. Энэ үед хоёр улсын эрдэмтэд,

¹⁵⁹ 「和達清夫気象台長がモンゴル気象台長あて書簡送付、相互主義に基づく気象関係資料の交換を申し入れた」、日本外務省外交史料館「日本モンゴル関係資料」25頁。

¹⁶⁰ 「モンゴル人民共和国政府はソビエト社会主義共和国連邦と日本国との両国関係の復活を歓迎するとともに、モンゴル人民共和国と日本との交渉に入る用意があることを声明する」日本外務省外交史料館「日本モンゴル外交樹立資料1959年—1966年、国会答弁資料」2頁。

¹⁶¹ 「日本は、モンゴルが独立国としての儀式を整えているかどうかのこと、国際社会における権利義務履

行の十分なる能力があるかどうか疑問があること、外交関係樹立は考えていないこと」、日本外務省外交史料館「日本モンゴル関係資料」26頁。

¹⁶²

「日本・モンゴル外交関係の樹立のこと、日本・モンゴル経済文化関係の促進のこと、モンゴルの国連加盟のこと」、同上書、26頁。

¹⁶³ 日本外務省外交史料館「日本モンゴル関係資料」26頁。

худалдааны төлөөлөгчид харилцан зорчиж, албан бус харилцаа ямар нэг хэмжээгээр явагдаж байсан байна.

Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар яриа хэлэлцээр өрнөж эхлэсэн нь

1961 онд 6 дугаар сарын 5-нд Варшав дахь Монгол улсын элчин сайд О. Бат-Очир Япон улсын элчин сайдын яаманд айлчлан яриа хэлэлцээ хийсэн нь албан бус анхны хэлэлцээр байсан хэмээн үздэг. Энэхүү уулзалтын үеэр хоёр улсын хооронд ойлголцлын зөрүүтэй байсан томоохон асуудлуудаар харилцан санал солилцсон. Тухайлбал Монгол улсаас Япон улсад хандан нэхэмжилсэн дайны төлбөр; Монгол улсын тусгаар тогтнолыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөх зэрэг асуудлууд байсан. Японы элчин сайдын зүгээс “Монгол улс НҮБ-д элсээгүй тохиолдолд хүлээн зөвшөөрөхгүй, дипломат харилцаа тогтоох асуудал яригдах боломжгүй”¹⁶⁴ гэсэн байр суурийг илэрхийлсэн. Энэ нь тухайн үеийн Япон улсын гадаад бодлогын үзэл баримтлал нь “НҮБ төвтэй гадаад бодлого” дээр тулгуурлаж байсантай холбоотой байсан байж болох.

1945 он 2 сарын 11-нд дайн дууссаны дараа Япон, Герман улсуудыг хэрхэх талаар ЗХУ-ын Крым-ын хойгийн Ялтад болсон гурван этгээдийн хэлэлцээрийн үеэр Сталин Черчилль, Рузвельт нарт хандан: “Хаант Оросын эзэмшилд байсан Хятадын зүүн хойд газар нутаг дахь эрхээ сэргээх; гадаад Монгол улсын статус квог хэвээр хадгалах аваас ЗХУ-ын зүгээс Дундад Иргэн улсын коммунист намыг биш Чан Кайшигийн засгийн газрыг ямар нэгэн болзолгүйгээр дэмжинэ” гэдгээ илэрхийлэн, хүлээн зөвшөөрүүлсэн байдаг.

Энэхүү тохиролцооны дагуу гадаад Монголд 1945 оны 10 сарын 20 -нд бүх нийтийн санал асуулгыг явуулж Монгол улсын тусгаар тогтнолыг Дундад Иргэн Улсын засгийн газраас 1946 он 1 дүгээр сарын 5-нд хүлээн зөвшөөрсөн. 1949 онд БНХАУ-ыг шинээр тунхаглан зарлаж, Монгол улстай Дундад Иргэн Улсын үед байгуулсан бүх гэрээ журмыг дагаж мөрдөхөө илэрхийлэн, мөн оны 10 сарын 6-нд БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон.

Монгол улс өөрийн тусгаар тогтнолоо 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал, 1921 он Ардын хувьсгалтай холбож үздэг. Харин Япон улс Монгол улсын тусгаар тогтнолыг 1946 оны 1 сарын 5-ны өдөр де юре (de jure) хэмээн үзэж байсан. Япон улсын энэ байр суурь нь Монгол улс *дайны төлбөр нэхэмжлэх эрх зүйн үндэслэлгүй* хэмээн үзэхэд хүргэж байв. Үүнийгээ 1939, 1945 онд Монгол улс тусгаар тогтнолоо олоогүй, олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан, тийм учраас дайны төлбөр нэхэмжлэх эрхгүй хэмээн тайлбарлаж байсан.

Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох үйл явцыг сунжруулахад нөлөөлсөн шалтгааны нэг нь энэ байсан. Үүний зэрэгцээ Монгол улсыг хүлээн зөвшөөрөх аваас Тайвань болон Хятад улстай харилцах харилцаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж Япон улс үзэж байсан байна.

Хэдий тийм боловч Монгол улстай дипломат харилцаа тогтоосон тохиолдолд Монголоор дамжуулан ЗХУ, БНХАУ-ын талаар мэдээлэл цуглуулах боломж нээгдэх, цаашилбал Хятад улстай ч дипломат харилцаа тогтоох асуудал илүү нээлттэй болно хэмээн Япон улс тооцож байжээ. Энэ цаг үе нь олон улсын харилцааны хүйтэн дайны үе байсан. Япон улсын хувьд Америктай харилцах харилцаа эн тэргүүнд байсан учир ЗХУ-тай дотно харилцаа бүхий Монгол улстай дипломат харилцаа тогтоох асуудалд онцгой хянуур болгоомжтой хандаж байсан нь түүхэн баримтад хийсэн судалгаанаас харагддаг.

164

「モンゴルが国連に加盟しない限り、承認ないし外交関係樹立の問題は起こり得ない」、日本外務省外交史料館「モンゴルとの外交関係樹立問題 戦後の接納開始資料」31頁。

1961 онд Монгол улс НҮБ-д гишүүнээр элсэх асуудал дахин идэвхитэй яригдаж эхэлсэн. Энэ үеэр Япон улсын засгийн газар Монголын талаар тодорхой мэдээлэлгүй, Монголтой харилцах бодлогын баримжаалалгүй байх нь зохисгүй хэмээн үзсэний үндсэн дээр 1961 оны намар гадаад харилцааны хоёр ажилтнаа Монголын нөхцөл байдалтай танилцуулахаар хүсэлтээ илэрхийлсэн байдаг.

Япон улсын засгийн газрын анхны энэхүү албан ёсны хүсэлтийг Монгол улсын засгийн газар хүлээн авч, мөн оны 9 сарын 23-наас 10 сарын 23-н хүртэл нэг сарын хугацаагаар монгол оронтой танилцах эрхийг японы хоёр ажилтанд олгосон байдаг. Энэ хоёр ажилтны бичсэн **“Монголд хийсэн ажиглалтын тайлан”**¹⁶⁵ нэртэй баримт мэдээлэл нь Япон улсын засгийн газрын Монгол улсын талаарх ойлголт төсөөлөл, баримтлаж байсан бодлогыг өөрчлөхөд томоохон хувь нэмэр оруулсан гэж Японы гадаад хэргийн яамны архивын баримт бичигт тэмдэглэгдсэн байдаг.

Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоох үйл явцад тулгарсан бэрхшээл

Монгол улс, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтооход дайны өр төлбөрийн асуудал, үзэл суртлын зөрүү зэрэг саад тотгор байсан нь илэрхий юм. Үүний зэрэгцээ ЗХУ, БНХАУ, Тайвань болон АНУ-ын баримталж байсан улс төрийн байр суурь, бодлого гол нөлөө үзүүлж байсан. Юун түрүүнд Монголын талаар Тайваний засгийн газраас баримталж байсан бодлогыг авч үзье.

Японы улсын засгийн газар 1952 оны 4 сарын 28-нд Чан Кайшигийн тэргүүлдэг Гоминданийн нам, түүний засгийн газартай **“Хятад-Японы энхтайвний гэрээ”** (Sino-Japanese Peace Treaty「日華平和条約」)¹⁶⁶-г байгуулан дайны байдлыг зогсоосон. Энэ цаг үед Тайваний засгийн газар нь НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн улс байсан бөгөөд Монгол улсын НҮБ-д гишүүнээр элсэхэд ямагт саад болж байсан. Тайваний засгийн газраас Монгол улсыг НҮБ-д гишүүнээр элсүүлэх асуудлыг бүх талаар эсэргүүцэж байсан бөгөөд бодит байдалд үл нийцэх өөрийн санаархлаа дэвшүүлж байсан. Тухайлбал:

- Монгол улс бол тусгаар улс биш, харин Тайваны нэг хэсэг юм;
- Монгол улс нь Солонгосын хойгийн дайныг дэмжсэн, эзлэн түрэмгийлэгч;
- Хэрвээ АНУ нь Монголыг дэмжвэл ардчилсан үзлээсээ ухарч байгаа хэрэг болно хэмээн шахалт үзүүлж, иймэрхүү утгатай мэдэгдлийг удаа дараа хийж байсан байдаг;
- Монгол улсыг НҮБ-д гишүүнээр элсүүлэхгүй байхын тулд АНУ нь бусад улсуудад шахалт үзүүлэх ёстой¹⁶⁷ хэмээн байр сууриа илэрхийлж байжээ.

Энэ бүхэн нь Тайваний засгийн газар Монгол улсыг өөрийн эзэмшил, бүрэлдүүн хэсэг хэмээн үзэж байсантай нь холбоотой. Монгол улс Тайваний засгийн газрын зөвшөөрөлгүйгээр Япон улстай дипломат харилцаа тогтоох эрхгүй гэж үзэж, хүчтэй эсэргүүцэж байсан. Мөн Бээжингийн засгийн газрыг Япон улс хүлээн зөвшөөрөхөөс Америк ихээхэн сэргийлж байсан. АНУ-ын засгийн газраас **“Бээжинг харж болохгүй, зөвхөн Тайванийг хар”**¹⁶⁸ хэмээн Япон улсад шахалт үзүүлж байсан. Харин Монгол улс нь БНХАУ бол нэг засгийн газартай, нэгдмэл улс, харин Тайвань бол Хятадын нэг хэсэг гэсэн байр суурийг баримталж байсан.

АНУ-аас Монголын талаар нааштай биш бодлого баримталж байсан. НҮБ-д гишүүнээр элсэх тухай Монгол улсын 1948 онд өгсөн өргөдөлд АНУ-ын шахалтын улмаас хариу өгөөгүй

¹⁶⁵ 日本外務省外交史料館「モンゴルを觀察報告書」(昭和36年11月)。

¹⁶⁶ 東京大学東洋文化研究所、条約集第30集第56巻。日本政治・国際関係データベース、<http://www.ioc.u-tokyo.ac.jp/~worldipn/documents/texts/docs/19520428.T1J.html>。2017/3/26

¹⁶⁷ 日本外務省外交史料館「モンゴルとの外交関係樹立問題の経緯、米国の対モンゴル打診工作資料」(中国課、昭和37年2月1日) 34頁。

¹⁶⁸ 服部龍二『日中国交正常化』(中央公論新社、2012年) 44頁。

байдаг. 1960 онд Монгол улс НҮБ-д гишүүнээр элсэн орох асуудлаа дахин тавих үед Монголын талаарх судалгааг АНУ-ын төрийн департаментын харьяа Хятад судлалын секторт хийсэн бөгөөд Монгол улсыг Азийн коммунист орнуудын бүлэгт хамааруулсан байдаг.

Монгол улс НҮБ-д гишүүнээр элсэх асуудал идэвхитэй тавигдаж байсан тэр үед АНУ-ын зүгээс “НҮБ дахь коммунист улсуудын тоо нэгээр нэмэгдэнэ хэмээн” болгоомжилж байсан боловч газар зүйн байрлалын хувьд ЗХУ, БНХАУ-тай харилцах стратегийн ач холбогдлыг бодолцон, Монгол улс НҮБ-д гишүүнээр элсэх асуудлыг тэгтлээ татгалзаагүй. Тэр үед Тайваний эсэргүүцэл хүчтэй байсан учир Монголын асуудлыг түр хойшлуулсан байдаг. Энэ нь Японы засгийн газраас Монголын талаар баримтлах бодлогод нөлөөлсөн байна.

АНУ-аас Монгол улстай харилцаа тогтоох ашиг сонирхол байсан. Тухайлбал: Монгол улс болон хил залгаа бусад улсуудын хооронд ямар нэгэн онцгой нөхцөл байдал үүсэхэд мэдээллийг шууд олж авах, бас БНХАУ-ын цөмийн зэвсгийн талаарх мэдээллийг авч, хяналт тавихад геостратегийн ач холбогдолтой гэж үзэж байв. Үүний зэрэгцээ дахин нэг коммунист улстай харилцаа тогтоосноор олон улсын тавцанд АНУ-ын нэр хүнд нь өснө хэмээн тооцоолж байсан байна.

АНУ Монгол улсыг НҮБ-ын гишүүн болохыг хүлээн зөвшөөрвөл Монгол улстай дипломат харилцаа тогтоох ёстой гэсэн үзэл бодол конгресс-д бий болж байсан. Энэ үеэс Монгол улсыг хүлээн зөвшөөрөх төсөл¹⁶⁹ Америкт 1961, 1969 онуудад хийгдэж байжээ. 1960 онд Сенатын гишүүн Мансфелд (Mansfield Michael Joseph) Монгол улстай хууль ёсны дагуу харилцаа үүсгэж чадвал ази дахь Америкийн бодлогод чухал ач холбогдолтой хэмээн мэдэгдэж байсан байна.

1949 оны 10-р сарын 1-нд БНХАУ-ын засгийн газар бүрэлдэн тогтсоноо зарлаж, БНМАУ-тай харилцах харилцааг хэвийн үргэлжлүүлэхээ нот бичиг солилцож мэдэгдсэн. 1956 оны 4 сарын 7-нд ЗХУ-ын сайд нарын зөвлөлийн орлогч дарга Анастас Иванович Микояныг БНХАУ-д айлчлах үеэр Ерөнхий сайд Жоу Энълай “Монгол урьд нь манай нэг хэсэг байсан. Сталин биднээс салгасан нь буруу үйлдэл болсон”¹⁷⁰ гэж ярьсан байдаг. Монгол улсыг БНХАУ-ын салшгүй хэсэг хэмээн үзэж байсан хятадын удирдагчдад ЗХУ-ын зүгээс “Монголын асуудлыг Бээжин ч шийдэхгүй, Москва ч шийдэхгүй, Улаанбаатар өөрсдөө шийдэх болно”¹⁷¹ хэмээн хариулж байсан.

Ийнхүү тэр үед Монгол улсын тусгаар тогтнолын асуудал дээр хөрш гүрнүүд бүрэн ойлголцолд хүрээгүй байсан явдал нь Япон улсын зүгээс Монгол улстай дипломат харилцаа тогтоох үйл явцад “харзнах, хүлээнэх” байдал бий болгож уг асуудлыг сунжруулахад хүргүүлсэн байж болох талтай.

1960 оны 5-р сарын 31-нд Монгол, Хятад хоёр улс харилцан бие биенээ хүндэтгэн, тус тусын халдашгүй дархан байдлыг хүлээн зөвшөөрч, харилцааг эрх тэгш явуулахаар тохиролцож, Найрамдлын Гэрээ¹⁷² байгуулсан. Энэхүү гэрээгээр талуудын хооронд үл ойлголцол, маргаантай асуудал үүсвэл яриа хэлэлцээний журмаар шийдэх, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд харилцан туслалцах, Ази тив болон дэлхий

¹⁶⁹ Memorandum from Stoessel to Goodpaster, United States Policy toward Outer Mongolia. Secret, Feb 4, 1961. Jonh F. Kennedy library, National Security Files, Countries Series, China, Outer Mongolia, General, CIA Cables, 1961.

¹⁷⁰ Cold war international project, *Sino- Soviet relations, Memorandum of conversation between Anastas Mikoyan and Mao Zedong* (Woodrow Wilson International Center for Scholars, 2001-2005.) p.348.

¹⁷¹

D.

Bumdari

「日本とモンゴルの外交関係樹立（1972年）—日・モ両国の外交交渉を中心に—」（国土館大学大学院、博士論文）、22頁。

¹⁷²同書、78頁。

дахинд энхтайвныг сахин хамгаалахад хүч чадлаа дайчлан хамтран ажиллах зэрэг асуудлуудыг тохиролцсон байдаг.

1961 оны 10 дугаар сарын 27-нд Монгол улс НҮБ-д 101 дэх гишүүнээр элсэн орсон. Монгол улс НҮБ-д гишүүнээр элсэхэд Тайваний засгийн газрын зүгээс аюулгүйн зөвлөлийн байнгын хороон дээр эсрэг санал гаргуулахгүй байхын тулд АНУ-аас Тайваньтай дараах дөрвөн зүйлийг тохиролцсон байдаг. Уг тохиролцоо нь Монгол улс НҮБ-д гишүүнээр элсэхэд АНУ эсрэг санал гаргахгүй бөгөөд АНУ-ын ерөнхийлөгч Кеннеди Тайванийг дэмжсэн байр сууриа илэрхийлэх; Чан Кайшид баталгаа гаргаж өгөх; үүний хариуд Тайвань нь Монгол улс НҮБ-д гишүүнээр элсэхэд татгалзахгүй байх¹⁷³ агуулгатай байлаа.

Ийнхүү Монгол улс ЗХУ болон найрсаг харилцаатай улс орнуудын тууштай дэмжлэгийн үр дүнд янз бүрийн саад тотгор, эсрэг байр суурийг даван туулж, НҮБ-д ямар нэгэн эсрэг саналгүйгээр (acclamation) элсэн орж олон улсын бүрэн эрхт гишүүн улс болсон юм.

Япон улс Монголын асуудлыг хэлэлцсэн НҮБ-ийн 16 дахь чуулганд оролцсон явдал нь Монгол улсыг цаагуураа хүлээн зөвшөөрсөн хэрэг хэмээн үзэж болох талтай. Энэ үеэс эхлэн албан ёсоор дипломат харилцаа тогтоогоогүй ч “де факто” хүлээн зөвшөөрч байгаа хэрэг хэмээн хоёр тал ойлголцож эхэлсэн. 1962 оны 8 дугаар сарын 30-нд Японы парламентат Монгол улсыг хүлээн зөвшөөрсөн эсэх талаар асуулга тавихад: НҮБ-д элсэх үед нь хүлээн зөвшөөрсөн¹⁷⁴ хэмээн хариулсан байдаг. Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтооход саад болж байсан цөөнгүй асуудлуудын нэг болох Монгол улс НҮБ-ын гишүүнээр элсэх асуудал шийдэгдсэн явдал нь Монгол, Японы харилцаанд эерэг нөлөө үзүүлсэн.

Дипломат харилцаа тогтоосон нь

Ийнхүү Монгол улс НҮБ-ын гишүүн болсон нь Монгол, Японы харилцаанд түлхэц үзүүлсэн. 1965 оны 8 сарын 3-17-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо НҮБ-ын Зүүн Хойд Азийн эдийн засгийн зөвлөл (ECAFE)¹⁷⁵-ийн бага хурал хуралдсан. Тус хуралд Япон улсаас хоёр төлөөлөгч оролцсон бөгөөд тус бага хурлын дараа Монголын холбогдох албаныхантай яриа хэлэлцээр хийх зорилгоор 30-ний өдөр хүртэл Улаанбаатар хотод үлдэж ажилласан байдаг. Япон улсын төлөөлөгчдийг Монгол улсын Гадаад яамны удирдлагууд 8 сарын 28-ний өдөр хүлээн авч уулзаж ярилцсан тухай протоколд тэмдэглэсэн байдаг.

Энэ уулзалтын хүрээнд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар Монгол улс, Япон улсын албаны хүмүүс харилцан байр сууриа илэрхийлсэн байдаг. Монгол улс байр сууриа дараах 6 зүйлээр илэрхийлсэн байна:

- 1957 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан мэдэгдлээр Монгол улс нь Япон улстай гадаад харилцаа тогтоох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн бөгөөд тэрхүү хүсэлт одоо ч хэвээрээ байгаа;
- Дипломат харилцаа тогтоосны дараа соёлын харилцаа тогтоох бодолтой байгаа;
- Монгол улс нь Япон улсын жишээгээр олон улсад нэр хүндээ өсгөх, өргөн хүрээтэй хүлээн зөвшөөрөгдөх бодлогыг баримталж байгаа;
- 1939 оны Халхын голын дайн, 1945 оны хоёр улсын хооронд үүссэн дайны байдал үргэлжилж байна. Иймээс Энхтайвны гэрээ байгуулах хэрэгтэй хэмээн үзэж байгаа;
- Халхын голын дайны талаарх хоёр улсын байр суурь зөрүүтэй байгааг ойлгож байгаа;
- Монгол улс нь Япон улсаас дайн төлбөрийг нэхэмжлэхгүй¹⁷⁶ гэсэн байна.

¹⁷³ Document # 72, Message from the Chief of Central Intelligence Agency Station in Taipei (Cline) to the President is Special Assistant for National Security Affairs (Bundy), Oct. 14, 1961. Ibid., FRUS, pp. 156-157.

¹⁷⁴ 日本外務省外交史料館「外蒙の承認に関する答弁案一、資料」(昭和37年1月23日)。

¹⁷⁵ The United Nations Economic Commission for Asia and the Far East- ECAFE

¹⁷⁶ モンゴル外務省外交史料館「日本との外交関係締結件—日本政府の外交員資料」1965年10月9日、3頁。

Япон улсын хувьд гэвэл: уг асуудал эхлээд хууль эрх зүйн хүрээнд боловсруулагдаж шийдэгдээгүй тохиолдолд дипломат харилцаа тогтоох асуудлыг авч үзэх боломжгүй; үүнтэй холбоотойгоор цаагуураа хүлээн зөвшөөрөгдөх, эс зөвшөөрөгдөхөөс үл шалтгаалан, одоогоор дипломат харилцаа тогтоох төлөвлөгөө байхгүй байгаа; газарзүйн байрлал болон бусад шалтгааны улмаас Монгол улсын талаар бодит мэдээллийг олж авахад бэрхшээлтэй байна; эхний хоёр асуудлаар идэвхитэй байж харилцаагаа үргэлжлүүлэх ёстой¹⁷⁷ гэсэн байр суурийг баримталсан нь томилолтын тайланд бичигдсэн байдаг.

1966 оны 3 сарын 8-нд Япон улсын “Дайнаас эргэж ирээгүй цэрэг”-ийн асуудал эрхэлсэн холбооноос Монгол улсын засгийн газарт хандан 1939, 1945 оны дайнд амиа алдсан Япон цэргүүдийн булшийг эргэх хүсэлтээ илэрхийлэн захиа илгээсэн байдаг. Монгол улсын засгийн газар энэхүү хүсэлтийг хүлээн авч шийдсэн. Японы талаас 1966 оны 8 сарын 24-нд ирсэн багийн бүрэлдэхүүнд дипломат харилцааны асуудлаар хэлэлцээ хийх мэдэл бүхий албаны хүмүүс багтаж ирсэн байна.

Монгол улсын гадаад хэргийн яаман дээр хоёр улсын албан бус хэлэлцээр 8 сарын 26, 27-ний өдрүүдэд болсон. Хэлэлцээрийн эхний өдөр хоёр улсын хооронд энхтайвны гэрээ байгуулаагүй учир дайны байдал үргэлжилж байгааг хэрхэх болон ЗХУ, Тайванийн байр суурийн талаар ярилцсан байна.

Хоёр дахь өдөр хийсэн хэлэлцээрийн дүнд хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох албан ёсны арга хэмжээг энгийн байдлаар хийж гарын үсэг зуралцах; дайны байдлын талаар баримт бичигт дурдахгүй байхаар; Энхтайвны гэрээ байгуулах нь гарцаагүй зүйл болох тухай; Гэрээ байгуулах үедээ дайны төлбөрийн асуудлыг нэг мөр шийдэхээр; Монгол улсын тусгаар тогтнолоо олсон он цагийн талаар хоёр тал “чимээгүй байх” зарчмыг баримтлахаар; дараагийн уулзалтыг Москва хотод хийх¹⁷⁸-ээр тус тус ойлголцсон байна.

Үүнээс хойш хоёр улсын хоорондын яриа хэлэлцээр гадаад орнууд дахь Элчин сайдын яамдаар дамжуулан, мөн олон улсын арга хэмжээний үеэр ч тасралтгүй явагдаж байсан. Монгол улс, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтооход дам нөлөө үзүүлсэн нэг үйл явдал бол “Никсон шок” юм. Япон, Америк хоёр БНХАУ-ын талаар ижил бодлого баримтлахаар тохиролцсон байсан боловч Америк энэ тохиролцооноосоо ухарч Япон улсаас нууцаар Хятадтай 2 жилийн турш харилцсан байдаг. Энэ явдал нь бие даасан бодлого явуулах, үндэсний эрх ашгаа хамгаалах талаар Японы парламентат томоохон маргааныг дэгдээсэн. Бие даасан гадаад бодлого явуулах үзэл санааны нөлөөн дор Монгол улстай дипломат харилцаа тогтоох үйл явц ч түргэссэн гэж үзэж болох юм.

Хоёр тал 1972 оны 1 дүгээр сард дипломат харилцаа тогтоох болсон. Монгол улсын засгийн газраас дайны байдлыг зогсоож, дайны төлбөрийг нэхэмжлэхгүй байхаар, хариуд нь Япон улсаас эдийн засгийн тусламж үзүүлэхээр харилцан тохиролцсон. 1972 оны 2 сарын 19-нд Москва хотод Монгол, Япон улсын засгийн газрын төлөөлөгчид хамтарсан мэдэгдэл хийж, дипломат харилцаа тогтоох талаар санал нэгтэй байгаагаа илэрхийлсэн. Ийнхүү 1972 оны 2 сарын 24-нд Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоож албан ёсоор баталгаажуулсан.

Дүгнэлт

¹⁷⁷ 日本外務省外交史料館「モンゴル在外館長（員）との接触に関する件」（昭和38年12月2日）。

¹⁷⁸ 日本外務省外交史料館「非公式会議録」22頁。

Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоох үйл явц багагүй хугацаагаар (1957-1972он) үргэлжилсэн. Энэ хугацаанд дипломат харилцаа тогтооход учирч байсан олон саад бэрхшээлийг даван туулсан.

Монгол, Япон улсын гадаад бодлогын түүхэн баримт бичиг, эх сурвалжийг судлан үзэхэд Монгол улс, Япон улс нь өөр өөрийн язгуур эрх ашгаа илэрхийлсэн бодлого, байр суурийг баримталж байжээ.

Монгол улс дэлхийн олон улсын нийтлэг эрх зүйн дагуу тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлж Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүнээр элссэн явдал нь Япон улсын зүгээс Монгол улсын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрөхөд том түлхэц үзүүлсэн. Тэр үед НҮБ төвтэй гадаад бодлого баримталж байсан Япон улсын хувьд Монгол улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсон нь Япон улсын зүгээс манай улстай харилцах харилцаанд урьд өмнө байсан хүлээзнэх байр суурийг өөрчилсөн.

АНУ болон Япон улсын хооронд байгуулсан аюулгүй байдлын хамтын ажиллагааны гэрээний дагуу социалист улс оронтой харилцах бодлогын асуудлыг хоёр тал урьдчилан тохиролцдог байсан тэр үед Япон улс нь Монгол улстай харилцах асуудал дээр бие даасан, уян хатан бодлого баримталсан явдал нь Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтооход аядуу зөөлөн нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Ном зүй, эх сурвалж

- 日本外務省外交史料館「日本モンゴル関係資料」
- 日本外務省外交史料館「日本モンゴル外交樹立資料 1959年 - 1966年、国会答弁資料」2頁。
- 日本外務省外交史料館「モンゴルとの外交関係樹立問題-戦後の接触開始資料」
- Memorandum from Stoessel to Goodpaster, United States Policy toward Outer Mongolia. Secret, Feb 4, 1961. John F. Kennedy library, National Security Files, Countries Series, China, Outer Mongolia, General, CIA Cables, 1961.
- Document # 72, Message from the Chief of Central Intelligence Agency Station in Taipei (Cline) to the President's Special Assistant for National Security Affairs (Bundy), Oct. 14, 1961. Ibid., FRUS.
- Cold war international project, *Sino-Soviet relations, Memorandum of conversation between Anastas Mikoyan and Mao Zedong* (Woodrow Wilson International Center for Scholars, 2001-2005.)